



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 06 өдөр

Дугаар 339

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 3.2 дахь хэсгийн заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 5.6, 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сангийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 12,190,518.40 (арван хоёр сая нэг зуун ерэн мянга таван зуун арван найман төгрөг дөчин мөнгө) төгрөгийн балансын үнэ, 10,359,709.49 (арван сая гурван зуун тавин есөн мянга долоон зуун есөн төгрөг дөчин есөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу тэг үлдэгдэлтэй хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоож балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Захиргаа удирдлагын албаны дарга Л.Сарнай, “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын дарга Б.Ичинхорлоо, Төрийн албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн дарга дэд хурандаа Л.Баттөр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д оруулан бүртгэх;

2.3. Автомашины улсын дугаарыг шилжүүлсэн тодорхойлолт, арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс /Д.Нарангэрэл/-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

000727

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрын 2020 оны 07
дугаар сарын 06-ний өдрийн 339
дугаар тогтоолын хавсралт

ТОГТООЖ БАЛАНСААС

Сангийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй тэг үлдэгдэлтэй хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоож балансаас
балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалт тад орсон он	Тоо шир хэг	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэх өртөг /төгрөг/	Шинэчлэн тогтоох үнэ	цаашид ашиглах жил	Хүлээн авах байгууллага
1	Гал тогооны тавилга /ком/	2011	1	2,366,000.00	2,366,000.00	2,089,967.02	276,032.98			"ДБҮЭГ" ТӨҮГ
2	Буйдан хар савхин /ком/	2012	1	4,180,770.00	4,180,770.00	3,065,898.00	1,114,872.00			ТӨБЗГазар
3	Ширээ туслах	2012	1	444,900.00	444,900.00	444,900.00	0.00	300,000.00	4 жил	ТӨБЗГазар
4	Ширээ хурал	2008	1	245,364.00	245,364.00	204,470.00	40,894.00			ТӨБЗГазар
5	Ширээ бичиг	2011	1	469,900.00	469,900.00	469,900.00	0.00	350,000.00	4 жил	ТӨБЗГазар
6	Шүүгээ шилэн өндөр	2008	2	374,900.00	749,800.00	749,800.00	0.00	300,000.00	4 жил	ТӨБЗГазар
7	Гал тогооны тавилга	2008	1	880,000.00	880,000.00	777,333.07	102,666.93			ТТАХНЭмнэлэг
8	ширээ сандал /ком/	2008	1	982,144.40	982,144.40	982,144.40	0.00	800,000.00	4 жил	ТТАХНЭмнэлэг
9	шилэн хорго	2008	4	467,910.00	1,871,640.00	1,575,297.00	296,343.00			
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		13 (арван гурав)		12,190,518.40 (арван хоёр сая нэг зуун ерэн мянга таван зуун арван найман төгрөг дөчин мөнгө)	10,359,709.49 (арван сая гурван зуун тавин есөн мянга долоон зуун есөн төгрөг дөчин есөн мөнгө)	1,830,808.91 (нэг сая найман зуун гучин мянга найман зуун найман төгрөг ерэн нэгэн мөнгө)	1,750,000.00 (нэг сая долоон зуун тавин мянга)		